

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/157/НА-СТА-ТШЗ

Чингис хот

2026 он

Цахим хаяг: www.audit.mn

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим
хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг:
oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 245

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗООНОЗ ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА
Ц.ГЭРЭЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн ЗӨСТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,025,562.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанд 20,984.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,008,355.0 мянган төгрөгийг зарцуулж, 38,191.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,366,351.2 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс үйл ажиллагааны орлого, үндсэн хөрөнгө, авлага ер төлбөрийн нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 70,020.3 мянган төгрөгөөр алдааг санхүүгийн тайланд залруулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,296,330.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлэв.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 5 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 97 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	366,204,855.38	414,133,574.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	18,633,689.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	149,424.45
335	Бусад авлага	-	18,484,265.00
3351	Байгууллагаас авах авлага	-	18,484,265.00
35	БАРАА МАТЕРИАЛ	339,704,455.38	369,009,485.38
351	Түүхий эд материал	283,792,075.38	313,262,705.38
35110	Тусгай зориулалттай материал	10,568,000.00	10,568,000.00
35130	Эм боох материал	273,224,075.38	302,694,705.38
354	Хангамжийн материал	55,912,380.00	55,746,780.00
35410	Бичиг хэргийн материал	4,536,600.00	4,555,600.00
35420	Аж ахуйн материал	50,027,780.00	50,282,180.00
35430	Сэлбэг хэрэгсэл	99,000.00	749,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,249,000.00	160,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	26,500,400.00	26,490,400.00
36600	Бусад нөөц	26,500,400.00	26,490,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,173,912,308.07	1,023,394,728.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,173,912,308.07	1,023,394,728.18
392	Биет хөрөнгө	1,023,586,308.07	873,068,728.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	769,282,849.00	769,282,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(144,213,159.10)	(161,510,358.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,700,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,700,000.00)	(29,700,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	575,444,515.45	588,292,357.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(183,833,897.57)	(326,569,786.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,662,170.60	16,232,170.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,756,170.31)	(12,658,503.63)
393	Биет бус хөрөнгө	150,326,000.00	150,326,000.00
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(730,000.00)	(730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	150,326,000.00	150,326,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,540,117,163.45	1,437,528,303.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,260.00	5,184,057.03
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,260.00	5,184,057.03
413	Өглөг	96,260.00	5,184,057.03
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	96,260.00	5,184,057.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,540,020,903.45	1,432,344,245.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,540,020,903.45	1,432,344,245.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,269,309.00	235,269,309.00
51101	Өмч: - төрийн	235,269,309.00	235,269,309.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,202,606,680.75	1,094,930,023.28
51210	Өмнөх үеийн үр дүн	1,202,606,680.75	1,202,606,680.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(107,676,657.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,144,913.70	102,144,913.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,540,117,163.45	1,437,528,303.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,387,616,637.64	1,059,394,506.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	388,773,507.64	33,832,106.80
120	Нийтлэг татварын бус орлого	388,773,507.64	33,832,106.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	388,773,507.64	33,832,106.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,857,850.00	20,984,265.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	380,915,657.64	12,847,841.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	998,843,130.00	1,025,562,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	986,431,800.00	1,025,562,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	986,431,800.00	1,025,562,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,411,330.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,411,330.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,096,214,827.00	1,167,071,164.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,096,214,827.00	1,167,071,164.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,084,852,675.67	1,147,063,757.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,312,823.65	814,342,144.89
210101	Үндсэн цалин	426,402,294.19	456,287,681.41
210102	Нэмэгдэл	192,257,707.15	247,338,252.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,488,832.85	50,680,382.32
210104	Урамшуулал	65,163,989.46	60,035,829.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш	93,779,153.60	103,093,653.29
210201	Тэтгэврийн даатгал	62,305,672.11	69,514,988.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,926,083.92	7,738,752.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,574,162.93	7,695,731.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,107,557.02	3,750,830.56
210205	Эрүүл мэндийн даатгал	13,865,677.62	14,393,349.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,140,532.42	22,666,662.51
210301	Гэрэл, цахилгаан	4,944,298.42	7,131,112.51
210302	Түлш, халаалт	11,734,200.00	13,221,500.00
210303	Цэвэр, бохир ус	7,462,034.00	2,314,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,045,355.00	21,636,025.00
210401	Бичиг хэрэг	5,426,030.00	1,009,250.00
210402	Тээвэр, шатахуун	15,150,000.00	16,240,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	682,800.00	624,275.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,786,525.00	3,762,000.00
2105	Нормативт зардал	54,520,983.80	9,259,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,420,983.80	9,259,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,613,700.00	2,560,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	950,000.00	132,000.00
210604	Урсгал засвар	21,663,700.00	2,428,750.00
2107	Томилолт, зочны зардал	19,528,000.00	8,499,600.00
210702	Дотоод албан томилолт	19,528,000.00	8,499,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	321,200.00	70,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	258,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,600.00	70,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,590,927.20	164,935,421.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	812,991.63	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,777,935.57	164,935,421.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,362,151.33	20,007,406.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,849,600.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,849,600.00	300,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилж	9,512,551.33	19,707,406.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,512,551.33	19,707,406.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>291,401,810.64</u>	<u>(107,676,657.47)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>291,401,810.64</u>	<u>(107,676,657.47)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,006,700,980.00	1,046,546,665.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,857,850.00	20,984,265.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,857,850.00	20,984,265.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,857,850.00	20,984,265.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,857,850.00	20,984,265.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	998,843,130.00	1,025,562,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	986,431,800.00	1,025,562,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	986,431,800.00	1,025,562,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,411,330.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,411,330.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,007,513,971.63	1,046,546,665.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,513,971.63	1,046,546,665.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	996,151,820.30	1,008,054,993.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,212,934.65	806,475,073.07
210101	Үндсэн цалин	426,302,405.19	448,420,609.59
210102	Нэмэгдэл	192,257,707.15	247,338,252.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,488,832.85	50,680,382.32
210104	Урамшуулал	65,163,989.46	60,035,829.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,782,782.60	106,022,352.53
210201	Тэтгэврийн даатгал	62,309,301.11	71,553,788.63
210202	Тэтгэмжийн даатгал	6,926,083.92	7,738,752.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,574,162.93	7,695,731.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,107,557.02	3,750,830.56
210205	Эрүүл мэндийн даатгал	13,865,677.62	15,283,249.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,229,532.42	23,445,812.51
210301	Гэрэл, цахилгаан	4,944,298.42	5,828,907.38
210302	Түлш, халаалт	12,823,200.00	10,111,750.00
210303	Цэвэр, бохир ус	7,462,034.00	7,505,155.13
2104	Хангамж, бараа материалын зардал	52,721,255.00	19,273,925.00
210401	Бичиг хэрэг	5,749,830.00	1,028,250.00
210402	Тээвэр, шатахуун	15,310,000.00	14,971,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	682,800.00	2,415,275.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,978,625.00	859,000.00
2105	Нормативт зардал	35,480,524.00	35,891,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,420,524.00	33,819,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,060,000.00	2,071,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,062,600.00	8,376,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,299,900.00	1,732,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,460,500.00
210604	Урсгал засвар	21,762,700.00	2,184,100.00
2107	Томилолт, зочны зардал	19,528,000.00	8,499,600.00
210702	Дотоод албан томилолт	19,528,000.00	8,499,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	321,200.00	70,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	258,200.00	45,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,600.00	25,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	812,991.63	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	812,991.63	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,362,151.33	38,491,671.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,849,600.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,849,600.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,512,551.33	38,191,671.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,512,551.33	38,191,671.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(812,991.63)</u>	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(812,991.63)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	812,991.63	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	911,204,870.11	1,248,619,092.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	911,204,870.11	1,248,619,092.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	291,401,810.64	291,401,810.64
C08	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	1,202,606,680.75	1,540,020,903.45
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	1,202,606,680.75	1,540,020,903.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	1,202,606,680.75	1,540,020,903.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(107,676,657.47)	(107,676,657.47)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	1,094,930,023.28	1,432,344,245.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,028,062,400.00	1,008,354,993.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,062,400.00	1,008,354,993.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,027,762,400.00	1,008,054,993.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	808,468,600.00	806,475,073.07
210101	Үндсэн цалин	447,530,300.00	448,420,609.59
210102	Нэмэгдэл	271,316,600.00	247,338,252.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,941,400.00	50,680,382.32
210104	Урамшуулал	52,680,300.00	60,035,829.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,708,600.00	106,022,352.53
210201	Тэтгэврийн даатгал	82,051,200.00	71,553,788.63
210202	Тэтгэмжийн даатгал	7,761,300.00	7,738,752.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,492,300.00	7,695,731.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,877,000.00	3,750,830.56
210205	Эрүүл мэндийн даатгал	15,526,800.00	15,283,249.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23473700.00	23445812.51
210301	Гэрэл, цахилгаан	5,829,000.00	5,828,907.38
210302	Түлш, халаалт	10,112,700.00	10,111,750.00
210303	Цэвэр, бохир ус	7,532,000.00	7,505,155.13
2104	Хангамж, бараа материалын зардал	19736900.00	19273925.00
210401	Бичиг хэрэг	1,311,700.00	1,028,250.00
210402	Тээвэр, шатахуун	14,971,400.00	14,971,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	2,415,275.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	131,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,400.00	859,000.00
2105	Нормативт зардал	35,895,600.00	35,891,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,490,700.00	33,819,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,404,900.00	2,071,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,395,500.00	8,376,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,732,000.00	1,732,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,479,400.00	4,460,500.00
210604	Урсгал засвар	2,184,100.00	2,184,100.00
2107	Томилолт, зочны зардал	8,500,000.00	8,499,600.00
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	8,499,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	583,500.00	70,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	206,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	231,300.00	45,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,100.00	25,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,100.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,300.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,028,062,400.00	1,008,354,993.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,025,562,400.00	987,370,728.11
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,025,562,400.00	987,370,728.11
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,500,000.00	20,984,265.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	20,984,265.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70,020.3 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Жилийн эцэст төвлөрүүлсэн 38,191.7 мянган төгрөгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлсөн.
2. Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 12,847.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор бүртгээгүй орхигдуулсан.
3. НДШ-ийн 149.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд 347.1 мянган төгрөгийн өглөгөөр тусгаж, НДШ-ийн авлага, өглөгийг 496.5 мянган төгрөгөөр зөрүүтэй хааж бүртгэн нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлсөн.
4. Жилийн эцэст төсөвт төвлөрүүлсэн 18,484.3 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардалд хаасан.

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 1,296,330.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны цахим системд санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг мэдээлэх хэсэгт хамааралгүй буюу 2023 оны аудитын тайланг мэдээлсэн, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт 47,971.4 мянган төгрөгийн 1 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 52,706.2 мянган төгрөгийн 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ хэсэгт 994,992.9 мянган төгрөгийн 13 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 103,558.9 мянган төгрөгийн 4 мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 44,365.9 мянган төгрөгийн 9 тушаал шийдвэр зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 1 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалтыг 4 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангиллыг 4 удаа, санхүүгийн тайланг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл зүйл "Шилэн дансны зарчим"-ийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төвлөрүүлсэн үлдэгдлийг орлогоор бүртгэсэн	1	38,191.7			1	38,191.7	1	38,191.7				
Үндсэн хөрөнгийг орлогоор бүртгээгүй орхигдуулсан	1	12,847.8	1	12,847.8			1	12,847.8				
Авлага, өглөгийг алдаатай бүртгэсэн	1	496.5			1	496.5	1	496.5				
Төвлөрүүлсэн ҮА-ны орлогыг авлагаар бүртгээгүй	1	18,484.3			1	18,484.3	1	18,484.3				
Дүн	4	70,020.3	1	12,847.8	3	57,172.5	4	70,020.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчил илрээгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн	1	1,296,330.9					1	1,296,330.9		
Дүн	1	1,296,330.9					1	1,296,330.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Зөрчил илрээгүй										
Дүн										
Нийт дүн	1	1,296,330.9					1	1,296,330.9		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 45-А 2370449

Чингис хот

ХЭА-2026/157/НА-СТА-ТШЗ

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг мэдээлэх хэсэгт хамааралгүй буюу 2023 оны аудитын тайланг мэдээлсэн, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт 47.9 сая мянган төгрөгийн 1 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 52.7 сая төгрөгийн 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ хэсэгт 995.0 сая төгрөгийн 13 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 103.6 сая төгрөгийн 4 мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 44.4 сая төгрөгийн 9 тушаал шийдвэр зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байна.

Мөн байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 1 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалтыг 4 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангиллыг 4 удаа, санхүүгийн тайланг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл зүйл "Шилэн дансны зарчим"-ийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Ц.Гэрэлмаа, нягтлан бодогч Н.Алтаншагай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ